

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-25

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	4-25
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
11 дүгээр сарын 19-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батбаатар, Э.Болормаа, Ө.Шижир;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Т.Доржханд, Ч.Лодойсамбуу, Ч.Номин,
Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Г.Уянгахишиг;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар;
Тасалсан: М.Бадамсүрэн, О.Цогтгэрэл.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын ахлах шинжээч Д.Сугар, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Райымбек, Г.Отгонцэцэг, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Чандмань, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Эрдэнэ, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбаямба, референт А.Амармэнд, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Ж.Баярмаа, Ц.Идэрбат, О.Саранчулуун, Ц.Сандаг-Очир, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн яамны Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 8.2 дахь дэд заалт нэмэх:

“2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БҮСИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “8.2” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “Ажлын хэсэг-5.2, 8.2” гэж “Салбар” баганад “Бүх салбар” гэж, “Үр дүн” баганад “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Хууль, эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 3 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “БҮСИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “8.2” гэж, “Салбар” баганад “Бүх салбар” гэж, “Үр дүн” баганад “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хот, тосгоны эрх зүйн байдлыг зохицуулсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: -” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026 онд 100, 2027 онд 100, 2028 онд 100, 2029 онд 100, 2030 онд 100” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Хагас жил тутам, Хариуцах байгууллага: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар” гэж” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	6
Бүгд:	18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 12 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 06 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Энэ 2 хаалгаа хаачхаач, наад нэг хаалгануудаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Жудагийн Баярмаа гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн, Доржзовдын Энхтуяа гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 асуудал хэлэлцэнэ. 1.Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, Байнгын хороо санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Саналтай гишүүн байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орёе. Ажлын хэсгийг оруулаарай.

Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. С.Бямбацогт Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, энэ ямар олон улсууд нь байхгүй юм бэ? Л.Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Ц.Амартөгс Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга, Д.Баянбилэг Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, энэ дуудаж байгаа улсууд байна уу? Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Б.Золбоо

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Ганбат Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, Г.Цэрэнжаргал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн үр дүнд суурилсан төлөвлөлтийн зөвлөх, Х.Сүрэнхорол Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Б.Мөнхтөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, П.Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжлийн нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Энэ яасан олон түр орлон гүйцэтгэгч нартай юм бэ? Б.Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлага хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, З.Райымбек, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Г.Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Д.Сугар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын ахлах шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгүүд ирсэн байна. Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Монгол Улсыг 2026-аас 30 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Зулпхар гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Өдрийн мэнд хүргэе. Би Бямбацогт сайдаас нэг зарчмын асуулт асуух гэсэн юм. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг анх санаачилж батлуулсан хүн бол та. Тэгээд энэ маш зөв асуудал болсон. Хамгийн гол нь Засгийн газар өөрөө тогтворгүй байгаад байнга бодлого нь өөрчлөгдөж байдаг, тогтвортой бодлогын залгамж халаа байдаггүй, нэгнийхээ эхлүүлсэн ажлыг улс төрийн агуулгаар ч тэр, нам дотроо ч тэр, нэг намынхан байсан ч сайд нь өөрчлөгдөнгүүт дахиад л нөгөө бодлого нь өөрчлөгдөөд ердөөсөө төсвийн үргүй зардал маш их яваад байна. Доороо ердөөсөө ингээд нөгөө дугуй ердөөсөө урагшлахгүй ингээд доороо л эргэлдээд байна гэдэг агуулгаар энэ Хөгжлийн бодлогын төлөвлөлт хуулийг гаргасан. Одоо энэ нэг жилийн төлөвлөгөөтэй холбоотой, нэг жилийн төлөвлөгөөг Улсын Их Хурлын гишүүд хэлэлцэхдээ улсын төсөв мэт ойлгож, өөрсдийнхөө төсөл, хөтөлбөрүүдийг оруулах гэж маш ихээр замбараагүйтүүлдэг.

Тэгээд үндсэндээ улсын төсөв болон нэг жилийн төлөвлөгөө хоорондоо ердөөсөө нийцдэггүй. Тэгэхлээр үндсэндээ энэ нэг жилийн төлөвлөгөөний хэрэг ер нь байна уу? Жишээлбэл 26 оны төлөвлөгөө бидний баталсан 26 оны улсын төсөвтэй огт нийцээгүй, хоорондоо өөр байгаа. Тэгэхээр аль аль нь буюу хөгжлийн төлөвлөгөө, нэг жилийн хөгжлийн төлөвлөгөө нь ч төсөвтэйгөө зөрчилдөж байна. Төсөв нь ч жилийн төлөвлөгөөтэйгөө зөрчилдөж байна. Тэгэхээр 1 жилийн төлөвлөгөөгөө ер нь больж болох уу? Тэгвэл энэ олон төрийн албан хаагчдаа ч тэр,

ер нь аль аль талдаа арай жоохон хөнгөрөх болов уу, нөгөө талдаа хууль биелдэг байх ийм зарчимтай байх болов уу гэсэн ийм нэг асуулт байна.

2 дахь нь болохлоор энэ бидний хэлэлцэж байгаа 26-аас 30 он хүртэл хэрэгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө маань 26 оны төсөв батлагдчихсан байгаа учраас төсөвтэй нийцүүлээд 26 оны төлөвлөгөөгөө өөрчлөх үү, эсхүл зүгээр энэ чигээр нь явах уу, эсхүл жилийг нь 27-гоос 31 болгох уу гэсэн ийм зарчмын асуултуудыг асууж байна?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон, Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн чухал асуудал. Яг таны хэлдэг үнэн, өнгөрсөн үндсэндээ 30 жил бид тийм төлөвлөлтгүй, бодлогогүй, төрийн бодлого нь тодорхой биш, бодлого төлөвлөлт байхгүй, төрийн бодлого нь тогтвортой биш, хоорондоо уялдаагүй явж ирсэн. Тэгээд үүнийг цэгцлэх гэж 19 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж. Үүн дээрээ тулгуурлаад Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг баталсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульдаа бид бодлогын төрийн бодлогын бичиг баримтууд гэж урт хугацаа, дунд хугацаа, богино хугацаа хоорондоо уялдаатай байх, урт хугацааны бодлогын бичиг баримт нь энэ байна, дунд хугацааных энэ байна, богино хугацааных энэ байна гээд бүгдийг нь тусгаад, эдгээрийг ингэж төлөвлөнө, ингэж зохион байгуулж, хэрэгжүүлнэ, хэрэглэгчдэд нь ингэж үр дүн тооцож, үнэлж дүгнэж, хяналт тавьж үр дүнг нь тооцно гэдгээ суулгаад өгчихсөн байгаа.

Үүний дагуу 21-ээс 25 оны үндсэн чиглэлийг бид ингээд 5 жилийн үндсэн чиглэлээр биелэлтийг дүгнэж үзсэн 100 хувь байх ёстойгоос 54 хувьтай л гарсан байна лээ. Анх 21 онд өөрөөр хэлбэл 21 онд төлөвлөж байх 100 хувь байх ёстой гэж төлөвлөсөн ажлууд маань 25 онд сая дүгнэхэд 54 хувийн биелэлттэй байж байгаа. Тэгэхээр цаашдаа бид үүнийг яаж үр дүнтэй болгох вэ, мөн алдаануудыг засаж яаж сайжруулах вэ гэдэг дээр Засгийн газар сайжруулж, 26-аас 30 оныг өргөн барьсан. Жилийн төлөвлөгөө улсын төсөв хоёрыг яаж уялдуулах вэ гэж. Нөгөө төлөвлөгөө байхгүй, зөвхөн төсөвтөө анхаараад 30 жил яваад ирчихсэн. Төсөв дээр л Улсын Их Хурал хэрүүл хийдэг, төсөв дээр л анхаардаг. Төсөвлөлт дээр л анхаардаг байсан бол үүнийг өөрчлөх бодлогыг бид 21 оноос эхэлж хийж эхэлсэн.

Жилийн төлөвлөгөө дээр, төлөвлөлт дээрээ тулгуурлаж, төлөвлөлт дээрээ үндэслэж төсөвлөдөг байя гэдэг юмыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар хийсэн боловч Төсвийн тухай хуульдаа болохоор төсөвлөлт нь чухал гээд ингээд биччихсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульдаа болохоор төлөвлөлт нь чухал гээд биччихсэн. Ингээд хууль хоорондын нийцэлгүй зүйл байгаад байгаа. Энийг бид цаашдаа засах ёстой. Ингэж байж жилийн төлөвлөгөө дээр суурилж төсөвлөлтөө хийнэ. Жилийн төлөвлөгөө үндсэндээ төрийн бодлогын богино хугацааны хамгийн эхний бичиг баримт, төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний жагсаалттай. Үүний дунд, богино хугацаанд дараагийн бичиг баримт бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 4 жилийн хугацаатай, үүний дараагийнх нь 5 жилийн үндсэн чиглэл, үүний дараагийнх нь 10 жилийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, хамгийн урт хугацааны бодлогын бичиг баримт Алсын хараа 2050 30 жилийн хугацаатай. Энэ бүхэн л хоорондоо уялдаатай байх ёстой, яг энэ бүгдийг л

хэрэгжүүлэх гэж Монгол Улсын төсөв санхүүг энэ бодлогыг хэрэгжүүлэх гэж л зарцуулах ёстой. Энэ бодлого маань л жоохон буруу хэрэгжээд байгаа юм.

Тийм болохоор мөн сүүлийн асуулт нь дахиад цаг сунгачих уу? 2 дахь асуулт нь. Ийм байдлаар тэгээд төлөвлөгөө чухал. Төлөвлөгөө чухал гэдгийг бүх гишүүд маань ойлгодог л болох хэрэгтэй байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон, 1 минут сунгая.

С.Бямбацогт: 26 оны төлөвлөгөө бас энд бидний нөгөө хууль хоорондын уялдаа хангагдаагүй үүнтэй холбоотой асуудал байгаа. Энийг бид засах ёстой. Өөрөөр хэлбэл 26 оны төлөвлөгөө баталчихсан. 26 оны төлөвлөгөө батлахаасаа өмнө уул нь бид 5 жилийнхээ үндсэн чиглэлээ батлах ёстой байсан. Цаглавар дээрээ алдаа гаргасан. Цаглавар дээр энийг сайн төлөвлөж тооцож чадаагүйгээс 26 оны төлөвлөгөө баталсны дараа Улсын Их Хурал одоо ингээд 26-аас 30 оны үндсэн чиглэлийг батлах гэж байгаа юм. Тийм болохоор 26-аас 30 оны үндсэн чиглэлийг батлах үедээ төлөвлөгөөгөө эргэж хараад, энэ хоёрыгоо хооронд нь уялдуулах шаардлага байгаа. Энэ үүнийг уялдуулах засах тийм үү, энэ дээр Засгийн газраас 185 дугаар ажлын хэсэг гарсан байгаа. Мөн Их Хуралд ажлын хэсэг гарсан байгаа шүү дээ Их Хурлын даргын захирамжаар. Энэ ажлын хэсэг дээрээ ярилцаад, энэ хууль хоорондын уялдааг хангах тал дээр төлөвлөгөө болон үндсэн чиглэл дээр өөрчлөлт оруулах боломж байгаа. Энийг ажлын хэсгийн явцад яриад.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн 1 минут тодруулъя.

А.Ариунзаяа: Тэгэхээр миний санал бол нэг жилийн төлөвлөгөөгөө ер нь болих. Яагаад гэвэл ердөөсөө бодит үр дүнд хүрэхгүй байгаад байгаа байхгүй юу. Зүгээр дунд хугацааныхыгаа гаргаад, тэгээд түүндээ нийцсэн яг төсөвлөлтийн бодлогоороо дагаад явбал уг нь аль, аль хуулийн зөрчилгүй болох юм уу л гэж харагдаад байгаа юм. Тэгэхгүй бол нэг жилийн төлөвлөгөө гэж хэдхэн хоногийн өмнө гаргачхаад, маргааш нь жилийн төсөв гэж огт өөр юм гаргаад байгаа нь өөрөө хоорондоо хуулийн нийцлийг байхгүй болгоод байгаа юм. Ийм учраас зүгээр дунд хугацаандаа нийцүүлсэн жил болгоны төсөв нь өөрөө энэ хөгжлийн төлөвлөгөө байж болохгүй юу гэдэг л асуудлыг дэвшүүлээд байгаа юм. Тэгэхээр 1 жилийн төлөвлөгөө маань өөрөө ердөөсөө хуульд нь нийцэх ямар ч тийм боломжгүй юм уу л гэж харж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон, Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тэгэхээр төсөв, улсын төсөв, улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө энэ 2 бодлогын бичиг баримт хоорондоо бас агуулгын хувьд өөр. Төлөвлөгөө бол төсөл, арга хэмжээний жагсаалтууд байдаг. Төлөвлөгөө бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтуудыг хэрэгжүүлэх энэ тийм үү, 4 жилийн хөтөлбөрийн нийлбэр. 5 жилийн үндсэн чиглэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаж байх ёстой, 5 жилийн үндсэн чиглэлтэй Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр уялдаж байх ёстой. 4 жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь жил жилээрээ задраад, жилийн төлөвлөгөө болдог. Энэ жилийн төлөвлөгөөгөө бол төсөв дээрээ суулгаж уялдуулж төсвөө батлах ёстой юм. Гэтэл бид төлөвлөгөөндөө ач холбогдол

өгдөггүй, төлөвлөгөөгөө гол бодлогын тулгуурлах бичиг баримт гэж үзэхгүй, ойлгохгүй байгаад байгаа учраас төлөвлөгөө хэрэггүй юм биш үү гээд байгаа юм. Уул нь төлөвлөгөө нь илүү чухал зайлшгүй байх ёстой, төлөвлөгөөгөө заавал биелүүлэхийн тулд төсөвлөлтөө хийдэг байх ёстой. Энийг л бид зөв.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Би ер нь асуулт биш, санал хэлчихье. Яах вэ энэ манай ажлын хэсгийнхэн нэлээн л ажилласан, боломжийн түвшинд эрдэмтдийн, судлаачдын хэлэлцүүлэг өрнүүлсэн гэж мэдээлэлтэй байгаа. Тэр нь ч угаасаа их сайн.

Гэхдээ нэгэнтээ бид энийг чинь батлахын тулд тийм бичиг баримт маань их алдаа мадаггүй л байвал сайн байх гэж бодож байгаа юм. Энэнтэй уялдсан байдлаар та бүхэн бас ахиад ажлын хэсэг дээр эргэж харах байх гэж бодож байгаа юм. Би зүгээр хоёрхон зүйлийг энэ засаглалын тэрэн дотроо төрийн удирдлагын хэсэг дээрээс зүгээр жишээ болгоод хэлчихье гэж байгаа юм. Төрийн удирдлага гэдэг энэ хэсгийн 7.3.1.2 дээр төрийн албан хаагчдын эдийн засаг, эрүүл мэнд, нэр хүнд, аюулгүй байдлын ийм баталгааг хангана гэсэн ийм зорилт тавьсан байгаа юм. Энэ бол зөв л дөө. Гэхдээ үр дүн нь болохоор төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ гэсэн ийм л үр дүнгээр хэмжигдээд, шалгуур үзүүлэлт нь болохоор сэтгэл ханамжийн дундаж үнэлгээгээр хэмжчихсэн байгаа юм.

Гэтэл энэ нөгөө эдийн засгийн баталгаа гэдэг чинь сэтгэл ханамжаар дангаараа хэмжигдэхгүй, цалин хөлсний бид их том бодлого хэрэгжүүлнэ шүү дээ. Тэгэхлээр тэр цалин хөлснийхөө бодлоготой уялдсан байдлаар шалгуураа тавивал яасан юм бэ гэсэн нэг санал байна. Тэгээд энэ дээр эрүүлгүй байдал, эрүүл байдал, эрүүл мэнд, нэр хүнд, аюулгүй байдлын ийм шалгуурууд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр тэрийгээ оруулахгүй бол саяын сэтгэл ханамжийн судалгаа дандаа энэ тааруухан гардаг юм. Ер нь бид хэзээ ч ингээд судалгаа авахад ер нь сэтгэл ханамж их тааруухан гараад байдаг байхгүй юу. Яг цалин нэмсний дараа бол цалинтай холбоотой харьцангуй өсдөг мөртөө. Тэгэхлээр энийг дараа нь та бүхэн мэдээж хэрэг жил жилдээ тайлагнахаар зэрэг ахиад л нэг ийм ороогдсон, асуугдсан юм болох байх, энийг та бүхэн иймэрхүү зүйлүүд байгааг анхаараач гэж байгаа юм. Тэгээд энэ дээр угаасаа хэн манай Бямбацогт сайдын өөрийнх нь шууд харьяаны байгууллага байж байгаа. Энэ Удирдлагын академийн яг энэ чиглэлээрх багш нарыг шууд оруулаад, энэ дээр шалгууруудыг нь судалгаан дээр нь суурилсан бол гаргачихмаар байна. Жил болгон хийдэг судалгаануудтай, тэрийгээ гаргачих байх гэсэн бодолтой байна.

Өөр нэг жишээ хэлье. Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг, орон тоог оновчтой тогтоох гэдэг үндсэн зорилт дотор 7.3.2.1 дээр олон улсын туршлага хамтын ажиллагааг нэмэгдүүлэх гэхихсэн байгаа юм. Яах вэ энэ байж болно. Гэхдээ бид өнгөрсөн жилүүдэд чинь байнга хийж байгаа, ярьж байгаа зүйл шүү дээ. 1 дүгээрт чиг үүргийн шинжилгээ хийх юм уу, хэдэн байгууллага дээр хийх юм бэ?

2 дугаарт бидний хийж байгаа зүйл бол байгаа, тэр нөгөө нэг системийн дахин инженерчлэл хийж байгаа шүү дээ, тэрийгээ хийх юм уу гээд ингээд энэ зүйлүүдээ зорилт болгоод тавьчихвал уг нь их зөв байх. Бид чинь ингээд угаасаа хийгээд явж байгаа зүйлээ шал хамаагүй юмаар орлуулчих вий гэж байгаа юм. Тэгээд эндээс ингээд харахаар зэрэг зарим зүйл дутуу байгаад байна л даа. Тэрийгээ болохоор зэрэг үр дүн дээр тавьчихсан байх юм. Үр дүн биш, тэр нь төрийн албан хаагчийн

сургалт, хөгжлийн тогтолцоог бид шинэ шатад гаргана гээд их том зорилт тавьчихсан байгаа юм. Энийг Бямбацогт сайд өөрөө ахалж байгаа. Тэрнийгээ зорилт болгоод, төрийн захиргааны албан хаагчдаа, төрийн тусгай болон бусад албан хаагчдын удирдах албан хаагчдыг сургадаг энэ шинэ бид чинь тогтолцоог бий болгоно шүү дээ. Тэрийгээ оруулаад, шалгууртай болгочихвол яасан юм бэ?

Ц.Сандаг-Очир: Санал хэлсэн үү? Бямбацогт сайд, ажлын хэсгийн 5 номерын микрофон хариулъя.

С.Бямбацогт: Тийм, Их Хурал дээр үндсэн чиглэлийг сайжруулах ажлын хэсэг гарсан байгаа. Энэ дээр Зулпхар гишүүн ажлын хэсэгт нь ороод саяын хэлж байгаа саналуудаа нэлээн ажил хэрэгчээр оруулаад, сайжруулаад явчхаасай гэж хүсэж байна. Энэ тэгэхдээ бас нэг жоохон ойлголтын зөрөө гэдэг юм уу, нэг зарчмын ялгаа байгаа. Ер нь бид ингээд төрийн албан хаагчдын тоог сүүлийн 10 жилд аваад үзэхээр 17 хувиар нэмэгдсэн байгаа. Төрийн захиргааны албан хаагч 8 хувиар, төрийн үйлчилгээ 16 хувиар, төрийн улс төрийн албан тушаалтнууд 19 хувиар, төрийн тусгай албан хаагчдын тоо 27 хувиар өссөн. Энэ өсөөд байгаа нь зөв байна уу, буруу байна уу энийгээ бид нэг анализ шинжилгээ хийж үзээд тийм үү, цаашдаа төрийн албыг бид цомхон, чадварлаг, илүү бүтээмжтэй, илүү ил тод, хүнд сурталгүй болгохын тулд яах ёстой юм. Мэдээллийн технологийн давуу талууд, хиймэл оюун ухаан бусад системийн инженерчлэл энэ бүгдийг ашиглаад илүү яаж цомхон болгох вэ, чадварлаг болгох вэ, зардал багатай болгох вэ энэ нэг асуудал.

Ажиллаж байгаа албан хаагчдын нийгмийн баталгаа, энэ ажиллаж байгаа хүмүүс маань ажилдаа сэтгэл хангалуун, амьдралдаа сэтгэл хангалуун, хийж байгаа ажилдаа дуртай, илүү бүтээмжтэй ажиллах нөхцөл бололцоог яаж бүрдүүлэх вэ дахиад нэг асуудал.

Эцэст нь төрийн үйлчилгээ яах гэж төрийн албан хаагч байгаа юм, ерөөсөө л төр түмэндээ хоёргүй сэтгэлээр зүтгэх, үйлчлэх үүрэгтэй. Төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх. Төрийн үйлчилгээг ард иргэдэд хэрхэн хүнд сурталгүй, нээлттэй, ил тод, хурдан шуурхай хүргэж чадах энэ үндсэн үүргээ биелүүлэх ёстой. Энэ үндсэн үүргээ хэрхэн, яаж биелүүлж байна энэнд нь иргэд сэтгэл ханамжтай байна уу, ханамжгүй байна уу энийг бид хэмждэг гол үзүүлэлт маань энэ рүү орох ёстой, энэ рүү. Ингэж байж төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг ил тод болгоё, иргэдээр үнэлүүлдэг байя. Зөвхөн дарга нарын үзэмжээр төрийн албан хаагчид ажилладаг биш, яг иргэдийн сэтгэл ханамжид нь хүрч ажиллахын төлөө чин сэтгэлээсээ ажилладаг, энийг нь тийм үү ажиллаж чадаж байна уу, үгүй юү гэдгийг нь үнэлдэг байх энэ юмнуудыг ингээд хамтад нь шийдэхгүй, бид зөвхөн өнгөрсөн алдаа бол төрийн албан хаагчдынхаа цалинг нэмэх ёстой гээд л овсгоотой удирдлагууд нь овсгоотой салбарууд нь цалингаа хангалттай нэмүүлчихдэг, нэг жоохон даруу нэрэлхүү улсууд нь цалингаа нэмүүлж чаддаггүй ингээд цалин хөлсний тогтолцоо алдагдчихсан.

Ингээд сая бол ирэх жилээс хувийн хэвшил бол төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэлд үндсэндээ чирэгдэхээр болж байгаа. Дахиад хувийн хэвшлээ чирдэг, үүнээсээ болоод үнийн өсөлт өсөх ийм сөрөг үр дагавруудтай байгаад байдаг. Нэмэгдлүүд нь, үндсэн цалин нь бага мөртөө авч байгаа нэмэгдэл нь түүнээсээ 2,5 дахин их үндсэн цалингаасаа. Энэ нь шударга юм уу, шударга биш юм уу гэх мэтийн бид юу гэдэг юм цалин хөлстэй холбоотой асуудлыг цогцоор нь шийдэх, дээрээс нь төрийн албанд сэтгэл хангалуун ажиллаж байгаа бол тэндээс

бүтээмж гаргах ёстой. Тэр бүтээмж нь ард иргэдэд сэтгэл ханамжийг бий болгож байх ёстой. Энэ юмыг л хийх зорилтуудыг тавьсан. Энэ хүрээндээ үндсэндээ өнөөдөр 141 дүгээр байранд тэр засаглалын индексээрээ манайх эрэмбэлэгдэж байгаа бол 2030 онд 33 байраар ахиулах, ингэж үр дүн гаргах ийм зорилтууд энд суусан байгаа. Төрийн албыг цомхон чадварлаг.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн 1 минут тодруулъя.

С.Зулпхар: Бямбацогт сайдтай санал нэг байна. Цалинг ярилаа, нэгэнт ярьсан юм чинь бас энийг ярья гэж бодож байна. Цалин хөлсний энэ тогтолцоо нэгдмэл байх ёстой юм. Одоо бид 30 гаруй хуулиар зохицуулчихсан ийм байгаа. Тэгэхлээр энийг шийдэх үүднээс Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл боловсруулаад уг нь бэлэн болгочихсон байсан юм. Энийг та бүхэн мэдэж байгаа байх. Ер нь цаашдаа тэгж явахгүй бол бид яг таны хэлдэг асуудалтай жил болгон тулгарах юм шиг байна. Үйлдвэрчний эвлэлтэй нь гараад жагсдаг, үйлдвэрчний эвлэлгүй төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагчид тэгээд дуугүй байдаг нэг ийм л байдал бий болж байна шүү дээ. Тэгэхлээр энийг нэгдмэл байдлаар саяын зүйл рүү оруулах нь зөв байх гэсэн ийм саналтай байна, цалин хөлсний тухайд бол.

Тэр бусад нөгөө гүйцэтгэлтэй холбоотой зүйлүүд тэртээ тэргүй тэр тооны тухайд бид анх ярьсан шүү дээ, цомхон чадварлаг биш, уг нь зохистой чадварлаг. Хэр байхыг бид чиг үүргийн шинжилгээгээр дахин инженерчлэл хийж байж тогтоох учраас энийг давхар оруулах нь зөв гэдэг дээр би санал нэг байна. Ингэж байж бид хэдүүлээ боловсруулсан цаас маань ч гэсэн дараа нь үр дүнгээ гаргахад хэрэг болохоор байна байх гэж бодож байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярмаа гишүүн асуултаа асууя. Идэрбат гишүүнийг нэмчхээрэй.

Ц.Идэрбат: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль гээд байгаа. Тэгээд энэ дээр ёстой их нарийн ингээд заасан юм шиг мөртөө тийм юу гэж хэлмээр юм асар олон ийм хөтөлбөр, төлөвлөгөө гаргах ийм шаардлагыг үүсгээд байгаа юм энэ хууль нь өөрөө. Төлөвлөгөө, хөтөлбөр гаргаснаараа Монгол Улс хөгжсөн бол өдийд үнэхээрийн бас л нэлээд их сэргэчихсэн ингээд явж байх ёстой. Миний санаж байгаагаар Шинэ сэргэлтийн бодлого гээд л байлаа, Алсын хараа 2050 гээд л байлаа, дунд нь хэчнээн үй түмэн хөтөлбөр ингээд хэрэгжүүлээд л яваад байдаг, яваад байдаг үр дүн нь юу вэ гэхээр байхгүй.

Тэгээд одоо ер нь энэ 5 жилийн төлөвлөгөө гэдэг чинь бас л яг нөгөө бидэнд өмнө нь ярьж байсан нөгөө социалист 5 жилийн төлөвлөгөө шиг л юм байгаад байна л даа. Гэтэл Засаг гараад яг 4, 4 жилээр өөрийнхөө төлөвлөгөөг батлаад явдаг. Тэгэхээр энэ 4 жил батлагдсан, ноднин батлагдсан дүрэм төлөвлөгөө, тэгээд 20, 30 хүртэл энийг зайлшгүй мөрдөх ёстой гэвэл нөгөө 2028 онд хэрвээ баруун төвийн үзэл баримтлал бүхий нам ялбал энэ өнөөдрийн баталж байгаа энэ 5 жилийн төлөвлөгөө буюу үндсэн чиглэлийг заавал ч үгүй мөрдөх ёстой гэдэг нэг ийм юм руу ороод байгаа юм.

Гэтэл энэ чинь үзэл баримтлал нь хэтээсээ өөр, төрийг аль болох цомхон болгоно гэдэг зүүний нам бол төр хүчтэй байх ёстой гэдгээс авхуулаад бүх тэр

төлөвлөх ёстой зүйлүүд нь уг нь өөр байх ёстой байгаад байдаг. Тэгэхээр ийм 5 жилийн төлөвлөгөө ер нь цаашид хэрэгтэй юм уу? Энийг ер нь нэлээн сайн ул суурьтай бодож үзэх нь зүйтэй байх. Эрх биш нэг урт хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр байхыг үгүйсгэхгүй. Тэгээд тэрнийхээ хүрээнд энэ Засгийн газрууд нь өөрсдийнхөө үйл ажиллагааг төлөвлөөд явахад болдоггүй юм уу гээд. Тэгэхээр энэ хуульдаа өөрчлөлт оруулах асуудлыг дахиж нэлээн нухацтай танай Засгийн газар ярих хэрэгтэй байх гэж бодож байна.

2 дугаарт нэгэнт ингээд батлахаас өөр замгүй хуульд өөрчлөлт орохгүйгээс хойш, дунд нь зөндөө нөгөө бодлогын хөтөлбөрүүд гардаг. Энэ дээр би нэг хөтөлбөрийг онцолж хэлмээр байна л даа. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр гээд 23-аас 30 оны хооронд гарсан юм байна. Тэгээд энэнтэй уялдаад гэх юм уу, аль нь алинтайгаа уялдаад байгаа нь ерөөсөө их ойлгомжгүй болчхож байгаа байхгүй юу. Ямар ч байсан ноднин бид баталсан 24-өөс 28 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт болохоор их сайн юм тусгачхаад байгаа шүү дээ. Нөгөө улс төр дэх мөнгөний нөлөөллийг багасгаж, сонгуулийн санал худалдан авалтыг зогсооё гээд. Энэ чинь өөрөө тэр Авлигын эсрэг хөтөлбөрт бүүр аягүй сайнаар тусчихсан байдаг юм билээ. Бүүр маш тодорхойгоор сонгуулийн үеийн санал худалдан авалтыг зогсоох, зорилт 1.2 дээр сонгуулийн бус үеийн санал худалдан авалтыг хориглох гээд маш тодорхой заачихсан, бүүр энийг би бүүр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минутдаа тодруулга авъя гэнэ, Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Тэгэхээр нөгөө Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энэ ажил маань ер нь юу болж байна, ямар шатдаа явж байгаа юм бол?

2 дугаарт энэ 5 жилийн үндсэн чиглэлд яг энэ сонгуулийн буюу сонгуулийн бус үеийн энэ санал худалдан авалтыг зогсоохтой холбоотой юу туссан юм бол? Энийг л бид зогсоож чадахгүй бол ерөөсөө энэ төр цэвэршихгүй. Бид өөрснөө байнга ярьдаг, овоо ойлгоод байгаа. Тэгэхээр энэ ирэх 5 жил ядаж нэг энэнээсээ бүрэн салах хэмжээнд юуг, яаж хийе гэж та нар төлөвлөж байна вэ? Нөгөө авлигатай холбоотой асуудлаа маш тодорхой заасан зүйл байна уу? 180 орноос манайх чинь нөгөө 114-д байгаа гээд, нөгөө Сьерра Леон гээд дайнтай орны ард байгаад байгаа шүү дээ. Беларусь гээд тоталитар дэглэмтэй улсын ард яваад байдаг. Тэгээд энийгээ яг ингэж, ингэж ажиллаад энэ 5 жилд тэд рүү хүргэнэ гэсэн маш тийм тоо заасан юм байгаа юу? Нэлээн ерөнхий л юмнууд харагдаад байна.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон, Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Дэлхийн банкны засаглалын индексийн авлигын индексээр Монгол Улс 2025 онд 138 дугаар байрт эрэмбэлэгдэж байгаа. Сүүлийн 5 жилийн хугацаанд хэдэн байраар 28 байраар хойшилсон, үгүй, ахиулах бид тийм үү, ирэх 5 жилийн хугацаанд. Өнгөрсөн сүүлийн, юу өмнөх 5 жилийн хугацаанд үндсэндээ авлигын индексээрээ бид байр ухраад 114-өөс 138 руу шилжчихсэн байна. Одоо 138-аас ирэх 5 жилийн хугацаанд 110 руу аваачиж, 28 байраар урагшлуулах ийм зорилго тавьж байгаа гэдгийг товчхон хэлье. Нэмэлт хариултуудыг манайхан өгч болно.

5 жилийн төлөвлөгөө хэрэгтэй юм уу, үндсэн чиглэл хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу гэж хэрэгтэй. Хамгийн чухал бичиг баримт. Дэлхийн улс орнууд ч энэ 5 жилийн

үндсэн чиглэл төлөвлөгөө бол маш олон улс орон баталж, мөрдөж хэрэгжүүлдэг. Манай 2 хөршөөс авхуулаад Казакстан, Швед, Норвег, Сингапур, Япон, Солонгос гээд бараг бүхий л улсыг хэлж болно. Та судлаад үзээрэй. Тийм болохоор хамгийн чухал бодлогын бичиг баримтаа бид ач холбогдлыг нь ойлгоод, энийгээ илүү харин яаж сайн хэрэгжүүлэх вэ гэдэг дээр анхаардаг баймаар байгаа юм. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлаад нэг их олон бодлогын бичиг баримттай болчихлоо гэж та асууж байна, гайхаж байх шиг байна. Судлаад үзээрэй. Урьд нь тийм үү 20 оноос өмнө Монгол Улс энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлахаас өмнө 600-аад хөтөлбөр, бодлого Их Хурлаар батлагдсан, хуулиас гадна шүү дээ. Одоо юу гэдэг юм салбар болгон байгаль орчныхон Байгаль орчны хамгаалах хөтөлбөр, Байгаль орчныг хамгаалах бодлого, Байгаль орчны усыг хамгаалах бодлого, ногоог хамгаалах бодлого, ойг хамгаалах бодлого гээд ингээд мангар олон бодлогын бичиг баримтуудыг Их Хурлаар батлуулдаг.

Тэр болгон нь хоорондоо зөрчилддөг. Тэгээд хүссэн нь тийм үү, нөгөө ой хамгаалах бодлогоо хэрэгжүүлэхгүй байна, чи ус хамгаалах бодлогоо хэрэгжүүлэхгүй байна, байгаль орчноо хамгаалах хөтөлбөрөө хэрэгжүүлэхгүй байна ийм олон бодлогын бичиг баримт Их Хурлаар батлаад, энэ 600 болчихсон байсан. Одоо тэгвэл энд яаж байна гэвэл Алсын хараа гээд 30, урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримт гээд 30 жил, дунд хугацааны хөгжлийн зорилт, хөтөлбөр гээд 8 зорилт, хөтөлбөр байгаа. Ингээд 5 жилийн үндсэн чиглэл, тэгээд энэ дээр тулгуурлаад Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн мөрийн хөтөлбөр, тэгээд жилийн төлөвлөгөө гэсэн ийм үндсэн 5 бичиг баримт Улсын Их Хурал батална. Үүнээс өөр бодлогын бичиг баримтыг яамнууд, Засгийн газар батлахгүй, тэгээд хуульчлаад өгчихсөн.

Урьд нь энэ 5-аас, энэ 600 байсан юм маань үндсэндээ бараг энэ 5 дотор орж багтаж байгаа. Энэ 5 чинь бол зарим нь ингээд 8 болж ингээд, үндсэндээ 20-иод бодлогын бичиг баримт дотор Их Хурал баталдаг болсон. Урьд нь 600 байсныг ингэж цэгцэлсэн. Хооронд нь уялдуулсан, давхардалгүй, хийдэлгүй, зөрчилгүй байх ёстой, хоорондоо уялдаатай байх ёстой, төрийн бодлого нөгөө тогтвортой байх, төрийн бодлого тодорхой байх, уялдаатай байх энэ үндсэн зарчмыг энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар хангаж өгсөн. 5 жилийн үндсэн чиглэл бол хамгийн чухал бодлогын бичиг баримт, хамгийн чухал. Урьд нь тэр Шинэ сэргэлтийн бодлого гээд ярьж байна. Энэ чинь нөгөө юу шүү дээ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулъя, 5 номерын микрофон.

С.Бямбацогт: Шинэ сэргэлтийн бодлогыг бид 21 онд баталсан. Энэ 5 жилийн нөгөө өмнөх 5 жилийн 21-ээс 25 оны 5 жилийн үндсэн чиглэл байсан. 26-аас 30 оны Үндсэн чиглэлээ бид Шинэ итгэл-эрс шинэтгэл нэртэйгээр өргөн барьж байгаа. 2024 оноос 28 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бол Хурдтай хөгжлийн төлөөх зориг хэмээх нэртэй Ардчилсан нам, ХҮН нам, Ардын нам 3 намын бодлогын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрт нь 80 хувийнх нь зорилтууд нь 80 хувь нь туссан ийм мөрийн хөтөлбөр байж байгаа. Энэ 5 жилийн үндсэн чиглэл, 4 жилийн мөрийн хөтөлбөр, жилийн төлөвлөгөө бүгд харилцан уялдаж явна. Өмнөхтэйгөө бас уялдах ёстой, хойдохтойгоо уялдах ёстой.

Шинэ сэргэлтийн бодлого хэмээх бид 5 жилийн үндсэн чиглэлийнхээ биелэлтийг дүгнээд үзэхэд 54 хувийн биелэлттэй гарсан. Улсын Их Хурал дээр хянаад, хэлэлцээд энэ дээр ажлын хэсэг маань анхаараад, өмнөх 5 жилийн үндсэн

чиглэлээс Шинэ сэргэлтийн бодлогоос юу нь хэрэгжээгүй байна, яагаад хэрэгжээгүй байна, цаашид энэ Шинэ итгэл-эрс шинэтгэл энэ хөтөлбөрт яг юуг нь, яаж суулгаж болох вэ гэдэг дээр ажлын хэсэг маань сайн ажиллаад өгөөсэй. Илүү сайжруулах, засах, хуульд нийцүүлэх, шаардлагатай бол хуулийг өөрчилж, илүү үр дүнтэй, гүйцэтгэл сайтай болгохын тулд анхаарах зүйлүүд байгаа байх. Энэ дээр манай Их Хурлын ажлын хэсэг маань энэ бодлогын бичиг баримтыг засаад, сайжруулаад, анхааралтай ач холбогдол өгөөд ажиллаад өгөөсэй гэж та бүхнээсээ хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Болсон уу Баярмаа гишүүн? 1 минут тодруулъя Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Тэгээд яах вэ нэг саналтайгаа хавсаргаад хэлчихье. Одоо бид энэ санал худалдан авалтыг зогсоох чиглэлд маш дорвитой ажил хийх ёстой байгаад байгаа юм. Сонгуулийн ерөнхий хороо, Авлигатай тэмцэх газар бол энэнд нэлээн ач холбогдол өгч ажиллах ёстой. Ялангуяа тэр авлигатай тэмцэх хөтөлбөр гээд батлаад, түүн дотроо уг нь суулгачихсан байгаад байгаа. Тэгээд Засгийн газраас энд маш их ач холбогдол өгч ажиллахгүй бол энэ маш тийм салбар хоорондын гэдэг шиг авлига гэж үзэж, Авлигатай тэмцэх газар маш их ач холбогдол өгөх ёстой. Тэгээд сонгууль гэдэг утгаараа Сонгуулийн ерөнхий хороо ач холбогдол өгөх ёстой. Тэгээд яах вэ Засаг бол энэ рүү орохгүй байгаа учраас би хувьдаа ямар ч байсан нэг энэ холбогдох байгууллагуудаас ажлын хэсэг гаргаад яг энэ Санал худалдан авалтын эсрэг хууль гээд анхдагч хуулийг боловсруулаад явж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Идэрбат гишүүн. Саранчулуун гишүүнийг нэмчхээрэй.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгээд манайх олон хөтөлбөрүүд баталж, хэрэгжүүлэх гээд ингээд л оролдож байгаа. Гэхдээ би арай илүү нөгөө амьдралд буугаад жоохон хэрэгжих гээд байгаа энэ юу нь Алсын хараа 2050 юм байна. Түүнтэй уялдсан энэ урт, богино, дунд хугацааны энэ хөгжлийн бодлогын хөтөлбөрүүд юм байна гэж ингэж харж байгаа. Тэгээд энэ хөтөлбөр батлагдсан цагаасаа 2 дахь 5 жил рүүгээ орох гэж байна шүү дээ тийм ээ. Гэтэл нэг дэх 5 жилийн маань төлөвлөлтийн биелэлт нь өөрөө 50 хувьтай байна гэдэг нь өөрөө яг энэ дээр яг ямар анализ дүгнэлт хийж байгаа вэ? Сая яах вэ сайд бол Их Хурлын гишүүд сайн ажиллаад өгөөрэй л гэж байна. Их Хурлын гишүүд бол бас яг тэгж сайн ажиллаж чадахгүй шүү. Яг ажил хариуцаж байгаа төрийн захиргааны алба хаагчид та нар энэ эхний 5 жилийн алдаа, оноо яг юу байсан юм бэ гэдэг дээр яг тийм бодитой дүгнэлт хэлж өгөөч гэж би 1 дүгээрт асуух гэж байгаа юм.

2 дугаарт сая тэр Ариунзаяа гишүүн асуугаад байна л даа. Бид 5 жилийн төлөвлөгөөгөө батлах гэж байж хоёр дахь 5 жил буюу одоо 6 дахь жилийнхээ төлөвлөгөөг батлах гэж байж төсөв, төлөвлөгөө хоёроо хооронд нь уялдуулаагүй явлаа. Тэгэхээр чинь хоёр дахь 5 жилийн суурь чинь буруу явчих юм биш үү? Энэ дээр яг ажил хариуцаж байгаа төрийн захиргааны алба хаагчид та нар юу гэж үзэж байгаа юм бэ? Энэ 2 дахь асуулт.

3 дахь нь болохоор төрийн албаны энэ тайлан дээр байна лээ. Төрийн албаны тогтвортой бус байдал өөрөө энэ бодлогын бичиг баримтуудыг, бодлогыг хэрэгжүүлэхэд маш төвөг учруулж байна гэж байгаа юм. Тэгдэг. Үнэхээр салбараа мэдэхгүй нэг нөхөр ирээд суучихдаг, юун хөгжлийн хөтөлбөр юу ч мэдэхгүй нэг нөхөр юм боловсруулна гэж тэгээд л нөгөө хүн багийн даргаас нь авхуулаад л

баахан юм нэхээд л, нэхээд л, нэхээд л суугаад байдаг. Тэгэхээр энэ дээр Төрийн албаны зөвлөл ер нь яг ямар бодлого барьж байгаа юм бэ? Төрийн албаны зөвлөл төрийн албан дотроо энэ ТЗ-ийн энэ чинь 20-иод мянган хүн байгаа билүү дээ, тийм ээ. 7, 8 хувь л байгаа шүү дээ. Энэ өөрөө асар их хөдөлгөөн орчихдог. Энэ хөдөлгөөнийг ер нь уул нь хуулиараа хорьчихсон. Гэтэл хууль хэрэгжиж байна уу, үгүй юү гэдэг дээр би маш их эргэлзээтэй байдаг юм. Энэ чинь ямар 220 мянган хүний хөдөлгөөнийг хянах гээгүй шүү дээ. Ядаж төрийн ТЗ-ийнхээ хүмүүсийг. Өнөөдөр ингээд баахан үүрэг гүйцэтгэгч нар байна. Хэзээ, хэний оронд орсныг мэдэхгүй. Бодвол шилж сонгоод л оруулсан байх. Тэгэхээр энэ дээр би сайдаас гадна энд яг ажил хариуцаад, сайдад асуудлыг танилцуулаад сууж байгаа төрийн албаны та бүхнээс асууя гэж ингэж бодсон юм.

Ц.Сандаг-Очир: Идэрбат гишүүний асуултад хэн хариулах вэ? Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Х.Сүрэнхорол: Эдийн засаг, хөгжлийн яам Сүрэнхорол. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас бол өмнөх 5 жилийн биелэлт дээр хяналт шинжилгээ, үнэлгээ мониторинг хийгээд, тайлангаа 9 сарын 11-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Уг тайлангаар ямархуу дүгнэлт гарсан бэ гэхлээр ер нь хөгжлийн бодлого, төлөвлөлтөө Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэх, үр дүнд суурилсан, илүү урт хугацаандаа үр дүнд суурилсан төлөвлөлтөө хийгээрэй гэдэг зөвлөмж гарсан байгаад байгаа юм. Тэгэхлээр тэр зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс бид 5 жилийн хөгжлийн төлөвлөлтийнхөө бичиг баримтыг боловсруулан орж ирж байгаа.

Өөрөөр хэлбэл нэгдмэл цогц, харилцан уялдаатай судалгаа, шинжилгээ, баримт нотолгоонд үнэлсэн, дээрээс нь оролцогчдын үүрэг хариуцлага тодорхой байх ёстой. Дээрээс нь өөрөөр хэлбэл smart буюу тодорхой, хэмжигдэхүйц, бодитой, бодлогын уялдааг хангах байдлаар боловсруулалтаа хийж орж ирээрэй гэдэг зөвлөмж өгсөн. Тэгэхлээр тэр зөвлөмжийнх нь хүрээн дотор 5 жилийн үндсэн чиглэлээ боловсруулж орж ирж байгаа.

5 жилийн үндсэн чиглэл маань 8 үндсэн чиглэлтэй. Дээрээс нь үндэсний 10 үр дүн, салбарын 35 үр дүн, төсвийн ерөнхийлөн захирагчийн 85 үр дүн, хөтөлбөрийн 200 үр дүн, тэгээд нийлээд 330 үр дүнг тодорхойлж орж ирж байгаа. Нэгэнт үр дүнгээ тодорхойлж орж ирж байгаа бол давхар шалгуур үзүүлэлтийг тусгах шаардлагатай байдаг. Тэгээд шалгуур үзүүлэлтийг 426 шалгуур үзүүлэлтийг тусгаж орж ирж байгаа. Мөн 5 жилийн үндсэн чиглэл дээр бас нэг асуудал юу байсан гэхээр зарим шалгуур үзүүлэлтийг тогтооход хүндрэлтэй байсан. Өөрөөр хэлбэл одоогоор тооцож чаддаггүй, Монгол Улс 40 гаруй шалгуур үзүүлэлтийг тооцож чадахгүй байгаад байгаа. Тэгэхлээр тэр шалгуур үзүүлэлтүүдийг бас тооцох шаардлагыг 5 жилийн үндсэн чиглэл дээр тусгаж орж ирж байгаа. Төрийн албаны зөвлөл нэмээд хариулъя тийм ээ.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 8 номерын микрофон, Төрийн албаны зөвлөлийн дарга Цэдэвсүрэн дарга.

Л.Цэдэвсүрэн: Идэрбат гишүүний асуултад 2 чиглэлээр хариулт өгье гэж бодож байна. Эхнийх нь ер нь энэ чадварлаг, ур чадвар сайтай төрийн албан хаагчдыг яаж бий болгох юм бэ гээд. Энэ өргөн барьчихсан байгаа төсөл дээр манай байгууллагын хариуцаж хийх ёстой 5, 6 ажлуудыг бид Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөр Алсын хараа 2050, 2026 оны жилийн төлөвлөгөө, сая батлагдсан улсын төсөвт гээд ингээд маш олон бодлогын бичиг баримтуудтай уялдуулж энэ томъёоллыг оруулж ирсэн. Харахад маш энгийн юм шиг төрийн албанд чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ, томилгооны зөрчлийг бууруулна гэдэг 1, 2-хон өгүүлбэр байгаа юм шиг харагдаж байгаа ч бид энэ дээр нэлээн реформын шинжтэй өөрчлөлтүүдийг хийхээр Засгийн газартай ажиллаж байна.

Хамгийн эхнийх нь юу вэ гээд. Бид ер нь ямар төрийн албан хаагчийг Монголд бий болгох гээд байгаа юм бэ? Чадамжтай, чадвартай хүнийг л төрийн албанд оруулмаар байна. Энэ хүрээндээ бид төрийн албан хаагчийн ур чадварын хүрээ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм, төрийн захиргаа, ялангуяа энэ төрийн албаны нэр хүндийг ер нь хамгаалдаг байх хэрэгтэй л дээ. Ингээд бүгдээрээ л төрийн алба ер нь их айхтар данхайлаа л гээд байдаг. Нэг сургууль баригдахад чинь 100 гаруйгаар нэмэгдчихэж байгаа юм. Тэгэхээр энийг бас нэг ялгаж салгадаг байгаасай гэж би 1 дүгээрт хүсдэг байхгүй юу.

2 дугаарт таны хариулт бол одоо байнга л ярьдаг нөгөө юм маань байна шүү дээ. Тэгэхээр таны яг ярих гээд байгаа энэ асуудлыг өмнө нь хийхэд юу саад болоод байсан юм бэ, төрийг нь яаж засаж байгаа юм бэ гэдэг чинь л чухал байхгүй юу. Тэрнээс чадварлаг байх ёстой, тогтвортой байх ёстой гээд ингээд л наадхыг чинь хамгаалаад, төрийн захиргаа л болчихвол насаараа байх нь гээд байгаль орчны байгаль хамгаалагчийг хүртэл ТЗ болгоод хаячихсан шүү дээ. Сөрөг үр дүн байгаа юу гэвэл бас байж л байгаа. Тэгэхээр энийг яаж засах гэж байгаа юм бэ гэдэг л юм би танаас асуугаад байгаа болохоос биш, яг юу гээд заачихсан юм бэ гэдгийг бол, урьд нь яагаад хийж болохгүй байсан юм бэ, одоо яг яаж хийх гэж байгаа юм бэ 1 дүгээрт? 2 дугаарт би энэ Баярмаа гишүүний.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ахиад 1 тодруулах минут Идэрбат гишүүн.

Ц.Сандаг-Очир: 2 дахь би нэг асуултаа асуугаад ингээд дуусгачихъя. Сая Баярмаа гишүүний асуугаад байгаа тэр юм бол их чухал байхгүй юу. Энэ 5 жилийн төлөвлөгөөг энэ завсар чинь Монгол Улсад 3 том сонгууль болох гэж байна. Тийм байгаа биз, энэ 26-аас 30 оны хооронд. Тэгэхээр олонх болсон нам хөгжлийн бодлогын энэ том бичиг баримтыг зайлшгүй мөрдөх ёстой гэдэг тийм хуулийн хамгаалалт яг юу байгаа вэ 1 дүгээрт?

2 дугаарт улс төрийн намууд, улс төрийн намууд болон нэр дэвшигчид сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулахдаа энэ чиглэлийг баримталсныг аудит дүгнэнэ гэж ингэдэг л болохоос биш яг мөргөж байна уу, үгүй юү гэдэг дээр тийм нарийн дүгнэлт бид гаргаж чаддаггүйгээс болоод ард иргэдэд энэ төлөвлөгөө биш ч юм шиг, бараг нэг өөр, энэ хүн л гарчихвал бүгдийг хийх юм шиг нэг ийм ингээд нэг популист амлалт руу сүүлдээ ингээд яваад өгдөг. Тэгэхээр энийг хянах.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номер, 6 номерын микрофон, 6.

Х.Сүрэнхорол: Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу 5 жилийн үр дүнг 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулна гэсэн зохицуулалт байгаа. Мэдээж сонгуулийн циклтэй холбогдуулаад хамгаалалттай зохицуулалтыг хийх бүрэн боломж бий. Улсын Их Хурал дээр 185 гээд Их Хурлын гишүүдийн ажлын хэсэг гарчихсан байгаа. Тэгээд тэр хүрээндээ бид 5 жилийнхээ үндсэн чиглэлийн цаашаа хэрэгжилтийг хангах, жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүд болон Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр холбогдох зохицуулалт, зохицуулалт буюу өөрөөр хэлбэл төсөл, арга хэмжээ байдлаар жил бүр хэрэгжих боломжтой байдлаар зохицуулалтуудаа тусгаад, тэгээд энэ хүрээн дээрээ төсвийн асуудлыг шийдээд явах ёстой гэдэг үндсэн байр сууриа илэрхийлээд явж байгаа. Тэгэхлээр ажлын хэсгийнхээ хүрээн дотор холбогдох хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн боломж бий.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: 2 асуулт тодруулъя. Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх гэсэн ийм арга зам төлөвлөсөн юм байна. Иргэний нийгмийн оролцоо гэдэг дээр та нар ямар шалгуур үзүүлэлтүүдийг тавиад, тэгээд тэрийгээ нэмэгдүүлнэ гэж хэмжих юм бэ гэдэг асуулт байна.

Хоёрдугаарх нь орон сууцны төрөлжсөн банк байгуулна гээд л яриад байгаа байхгүй юу. Энэ ер нь ямар бүтэцтэй, аль газрын харьяа, ямар байгууллага байх юм бэ? Яагаад гэхлээр энийг чинь ингээд нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, зорилтот бүлгийн олон нийт, олон хүмүүс энэ орон сууцны асуудал дээр нүдээ чилтэл хүлээж байгаа шүү дээ тийм ээ? Тэгэхээр энэ дээр ер нь яг ямар төлөвлөгөө тусгаж байгаа юм бэ? Яагаад гэвэл өнөөдөр энд Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ тэр гэсэн хариуцах газрууд байгаад байна л даа. Монголбанк байгаа байх гэж ойлгож байна. Тэгэхээр энэ хүмүүс нь орон сууцны төрөлжсөн банк гэж ямар хэлбэртэй, ямар бүтэцтэй, ямар байгууллагын тухай ярьж байгаа юм бэ? Энэ нь энэ 5 жилдээ яаж хэрэгжих тухай мэдээлэл өгнө үү? Тэгээд дараа нь тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Х.Сүрэнхорол: Эдийн засаг, хөгжлийн яам Сүрэнхорол. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар хөгжлийн бодлогоо төлөвлөхдөө олон нийтийн оролцоог хангах ёстой. Өөрөөр хэлбэл тал бүрийн оролцоог сонсож, холбогдох боловсруулалтыг нь хийх гэдэг шаардлага байдаг. Тэгэхлээр яг энэ шаардлагыг хангаж 5 жилийн үндсэн чиглэлээ боловсруулалтаа хийж орж ирсэн. Өөрөөр хэлбэл бид энэ хүрээндээ нийт 15 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Шинжлэх ухааны академийн 6 бага чуулган, 2 их чуулганаар энэ 5 жилийн үндсэн чиглэлээ боловсруулаад, хэлэлцүүлээд, холбогдох саналуудыг нь тусгаж орж ирсэн. Өөрөөр хэлбэл эдгээр хэлэлцүүлгийн явцад 644 санал гарсан. Тэгээд 644 саналаасаа бол яг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Эдийн засаг, хөгжлийн сайдын баталсан аргачлалд нийцүүлээд холбогдох саналуудыг тусгаад, 5 жилийн үндсэн чиглэл маань боловсруулагдаж орж ирсэн.

Орон сууцжуулалтын банктай холбоотой ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын яаман дээр бол гараад явж байгаа, Төрийн нарийн бичгийн дарга нь

ахлаад явж байгаа. Тэгээд тийм, энэ дээр Барилга, хот байгуулалтын яам хариулт өгөөд, үр дүнгээ тодорхой танилцуулах байх.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Хэдүүлээ одоо юу яана, жоохон иргэний нийгэм, олон нийт гэдэг зүйлээ хэдүүлээ жоохон тодруулцаа. Филантропи гэж юу билээ, иргэний нийгэм гэж юу билээ, хувийн хэвшил гэж юу билээ, төрийн бус байгууллага гэдгээ яаж байгаа вэ гэдгээ ялгах хэрэгтэй. Тэгэхээр хэлэлцүүлэгт урьж байгаа, хэлэлцүүлэгт ерөнхийдөө оролцуулж байгаа нь өнөөдрийн энэ арга хэмжээнд шалгуур үзүүлэлт болоод ингээд манай 5 жил бол ерөөсөө төрийн бус байгууллагуудаа хэлэлцүүлэгт уриад, оролцуулаад, тэгээд энэ оролцоог нэмэгдүүлнэ гэдгийг хэмжих юм уу? Хэлэлцүүлгээс өөр хувилбар одоо байна уу? Олон нийт үү, эсвэл иргэний нийгэм үү, эсвэл төрийн бус байгууллага уу, алийг нь ялгаж, ямар механизмаар тэд нарыгаа оролцуулах юм бэ? Яагаад би энийг асууж байна гэхлээр олон улсын болон Монголд байгаа маш олон төрийн бус байгууллагууд судалгаа хийдэг, бодлогын судалгаанууд хийгээд явуулаад байдаг байхгүй юу. Тэр энэ тэрийг ер нь яаж авч үздэг юм бэ? Энэ механизм жоохон ойлгомжгүй байгаад байгаа байхгүй юу.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Х.Сүрэнхорол: Эдийн засаг, хөгжлийн яам Сүрэнхорол. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиараа тухайн хөгжлийн бодлогыг боловсруулах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах тодорхой арга зүй байдаг. Өөрөөр хэлбэл дээрээс доош, энэ маань юуг хэлээд байна гэхлээр Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй бодлогын уялдааг хангах ёстой. Доороос дээш буюу төсвийн ерөнхийлөн захирагчтай холбогдох үр дүн, арга хэмжээнүүдээ боловсруулаад, хамтран боловсруулаад, үр дүнгээ тодорхойлоод явах ёстой. Тэгэхээр тухайн төсвийн ерөнхийлөн захирагчтай 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа яаж ажилласан бэ гэхлээр төсвийн ерөнхийлөн захирагчид маань тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагуудаа хэлэлцүүлэгт оролцуулах, дээрээс нь тодорхой үр дүнгүүдээ тодорхойлж гарч ирэхдээ тухайн байгууллагуудаасаа санал авах байдлаар боловсруулалтаа хийгээд, тэр маань Эдийн засаг, хөгжлийн яаман дээр яг хуулийнх нь.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ахиад сүүлийн 1 минут, Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Хэдүүлээ иргэдэд орон сууцны төрөлжсөн банк байгуулна гэдэг нь юу болох тухай өнөөдөр энэ хурлаараа хариулт өгчихье тэгэх үү? Хүлээж байгаа хүмүүс зөндөө байгаа шүү дээ. Тэгэхээр хэн хариулах вэ?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 2 номерын микрофон. Нэр, албан тушаалаа хэлээрэй.

М.Баяраа: Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Баяраа.

Ц.Сандаг-Очир: Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орлогод нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2025 оны 7 сарын 23-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Миний бие ажлын дэд хэсэг дээр Орон сууцжуулалтын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулаад явж байгаа. Ер нь концепцын хувьд болохоор орон сууцны төрөлжсөн банк байгуулснаар дэд бүтэц бүрдэж, арилжааны банкнаас олгох зээлийн хүүг бууруулах гэсэн энэ үндсэн ийм ач холбогдолтой. Ер нь яг бүтцийн хувьд болохоор одоо явж байгаа МИК-ийн тогтолцоо байгаа 6 хувь гээд, орон нутагт 3 хувийн хүүтэй зээлийг ингээд олгоод явж байгаа. Тэгэхээр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ахиад нэмж гүйцээж хариулъя, 2 номерын микрофон.

М.Баяраа: Та бүхэн мэдэж байгаа байх 2-оос 3 жилийн хэмжээний дараалал бол үүсчихсэн байгаа, эрэлт хэрэгцээ байгаа гэдэг. Тэгэхээр энэ хүртээмжийг нийгмийн бүх давхаргад хүргэх ийм үйлчилгээг бол энэ банкны тогтолцоо маань өөрөө хуулийг бий болгосноороо цааш нь хэрэгжүүлэх юм. Жишээ нь манайд явж байгаа бага хүүтэй, худалдаж авахаас гадна залуу гэр бүл, мөн түрээслээд өмчлөх, түрээслэх гэх мэтийн маш олон энэ хэлбэрийн зүйл заалтыг хуульчилж өгч байгаа. Мөн маш олон орон сууцны хөтөлбөр, хөтөлбөрүүд явдаг. Эднүүсийг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн тэр хэм хэмжээг нь бүрдүүлж өгч байгаа ийм ач холбогдолтой байгаа юм. Тэгэхээр бид энэ хуулийг бий болгосноороо хуучин ганцхан эрэлтийг ярьдаг байсан бол одоо энэ хуульд нийлүүлэлт талаасаа орох юм гэж тодотгож хэлье.

Ц.Сандаг-Очир: Үгүй ээ, сая шал өөр юм асуугаад байх юм Саранчулуун гишүүн. Банк, иргэдийн оролцооны банк гэсэн үү? Орон сууцжуулалтын банк. Үгүй ээ, шал өөр юм хариулаад байх юм. Алив ахиад Баяраа дарга 2 номерын микрофон.

М.Баяраа: Сая банкны хууль гэж яриад байна, банк, санхүүжилтийн саяынхаа банкийг бий болгох хуулийг, эрх зүйн орчныг бид эхний удаа хийе гэж байгаа юм. Тэгээд энэ дээрээ болохоор 2 хуулийн төслийг өргөн барья гэж байгаа. Нэг нь болохоор орон сууцжуулалтын санхүүжилтийн тийм банкны тухай хууль, нөгөөдөх нь Орон сууцны тухай хууль. Энэ нь болохоор нийлүүлэлт талыг хариуцсан ийм 2 хуулийг бий болгож, энэний хүрээнд хуулиа өргөн барья гэж ингээд явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Нэмж ажлын хэсгийн 6 номерын микрофон, Сүрэнхорол дарга.

Х.Сүрэнхорол: 5 жилийн үндсэн чиглэлд Орон сууцжуулалтын банктай холбоотой үр дүнг тусгасан. Үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь хэсэгт орон сууцны төрөлжсөн баг байгуулах замаар орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ. Үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтын 4.4.1.3 дахь хэсэгт орлогод нийцсэн хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоог 2024 онд 12125 байгаад байгаа суурь дүн маань 2024 оны статистик дүнгээрээ, тэгээд 2030 онд болохлоор 68850-д хүргэнэ гэдэг үр дүнг тусгаж орж ирж байгаа. Тэгэхлээр нөгөө Орон сууцжуулалтынхаа банкны тухай хуулийг боловсруулаад, хэрэгжилтээ хангаад явахлаар ийм үр дүнд хүрнэ гэдэг Барилга, хот байгуулалтын яамны 2030 оны төсөөлөл нь ийм төсөөлөл гаргаж ирж, үр дүнд тусгаж орж ирсэн.

Ц.Сандаг-Очир: Би ганц нэг асуулт асууя. 21-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 21-ээс 26 онд хөгжүүлэх үндсэн чиглэл ялгаа нь юу вэ? Өмнөх 5 жилийн хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэлийн биелэлт 50 хүрэхгүй хувьтай байгаа. Тэгээд ахиад сору-доод ингээд оруулаад ирчихсэн, одоо ахиад 5 жилийн дараа ингээд л ахиад л 50 хүрэхгүй хувьтай сууж байх уу? Ялгаа нь юу байгаа юм бэ? Өнгөрсөн 5 жилийн үндсэн чиглэлийн энэ биелэлт тааруу байгаад ямар дүгнэлт хийсэн юм бэ Эдийн засаг, хөгжлийн яам? Энийгээ засаж сайжруулах ямар төлөвлөгөө оруулж ирсэн юм бэ гэдгийг нэгд асууя?

2-т манай Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд засаглал дижитал шилжилт гээд 7 дугаар бүлэг энэ нэг ийм субъектив байдлаар байгаа асуудлуудын хэмжих нэгж нь юу юм бэ гэж? Нэгд төрийн байгууллагуудын шударга байдлыг нэмэгдүүлнэ гэж 7.1.1.1, төрийн байгууллагуудын шударга байдлыг нэмэгдүүлнэ энийг яг юу гэж ойлгох юм бэ, хэмжих нэгж нь яг юу юм бэ, 5 жилийн дараа яг төрийн байгууллагуудын шударга байдал ингэж сайжирсан юм гэдэг нь яаж хэмжих юм бэ, одоо ямар байгаа юм бэ энийг нэг та бүхэн хэлж өгөөч?

Төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ гэж 7.3. Одоо ямар байгаа юм бэ, яг 5 жилийн дараа төрийн бүтээмжийг хэмжих хэмжүүр нэгж нь юу юм бэ? Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны бүтээмж, ажлын үр дүнг юугаар хэмждэг юм бэ? Төрийн албанд чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ, төрийн албан хаагчийн томилгооны зөрчлийг бууруулна гээд, одоо ямар байгаа юм бэ, 5 жилийн дараа ямар болгох юм бэ Төрийн албаны зөвлөлийнхөн? Нөгөө талаар энэ хөрөнгө оруулалт гээд нэг, хөрөнгө оруулалтын хөтөлбөр гээд байна Эдийн засаг, хөгжлийн яамныхан анхаарна биз. 4.1 нь санхүүгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт гээд 80 гаруй хөрөнгө оруулалтын ажил байна тийм үү? Дараа нь ахиад 4.2 дээрх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд гээд бас нэг ингээд 70, 80-аад хөтөлбөр байна.

Дараа нь ахиад 4.3 дээрээ хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт гээд байна. Тэгээд ингээд баталчихаар эх үүсвэргүй эд нарыг ирэх 5 жилийн хугацаанд хийнэ гэж ойлгож байгаа юм уу? Эх үүсвэрийг нь хаанаас бүрдүүлнэ гэж ойлгож байгаа юм бэ, ингээд баталчихсанаа дараа бид яах ёстой юм бэ энийг? Засгийн газар энэ дээр ямар, Эдийн засаг, хөгжлийн яам ямар бодлого, байр суурь баримталдаг юм бэ? Бид ингээд батлагдчихсан гэж ойлгож болох уу, үгүй юү? Энэ төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл хөтөлбөрүүд гэсэн 4.3-ыг юу гэж ойлгох вэ? Эх үүсвэр байхгүй байгаа юмнуудыг батлах гэж байна шүү дээ бид. Энийг юу гэж ойлгох вэ гэсэн нэг ийм асуултад та бүхэн хариулж өгөөч. Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Х.Сүрэнхорол: 2026-аас 2030 оны 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа бид ер нь үр дүнд суурилсан хамгийн анхны удаагийн төлөвлөлт бол анх удаа ингэж орж ирж байгаа. Тэгэхлээр өмнөх нөгөө 5 жил маань ямархуу нөхцөл байдалтай байсан гэхлээр ерөөсөө төсөл, арга хэмжээ үр дүн холилдчихсон байсан гэсэн үг. Тэгэхлээр нөгөө үр дүнгээ тодорхойлж орж ирэхгүй болохлоор бид тооцож хэмжихэд хүндрэлтэй болчихож байгаа юм. Тэгэхээр бид энэ дээр 5 жилийн үндсэн чиглэл дээр яг үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүй буюу өөрөөр хэлбэл олон улсад хэрэглэдэг яг төлөвлөлтийн арга зүйг баримтлаад, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуультайгаа нийцүүлээд орж ирж байгаа. Тэгэхлээр энэ хүрээн дотор бид ямар зарчмыг бариад байна гэхлээр нэгдмэл л байх ёстой, цогц. Өөрөөр хэлбэл нөгөө бүх салбаруудын үр дүн, төсвийн ерөнхийлөн захирагчдын үр дүн,

дээрээс нь үндэсний үр дүн, хөтөлбөрийн үр дүнгүүд маань бүгдээрээ нэгтгэж орж ирж байгаа. Нийт 330 үр дүн тодорхойлсон.

Дээрээс нь 3 дугаар хавсралт дээр 426 шалгуур үзүүлэлтийг тодорхойлж орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл тухайн үр дүнгээ ямар шалгуур үзүүлэлтээр хэмжээд, 2025 оны 2024 оны суурь статистик дүн маань ийм байна, 2026, 27, 28, 29, 30 онд ямар үр дүнд хүрэх юм бэ гэдгийг нэг бүрчлэн тусгаж орж ирж. Өнгөрсөн 5 жил дээр яах вэ үр дүн, төсөл, арга хэмжээ холилдоод ороод ирсэн. Тэгэнгүүт 2021, 2022 ч гэдэг юм уу, 2022, 23, 24 онд ямар үр дүнд хүрэх юм бэ гэдэг нь 5 жилийн үндсэн чиглэл дээр байхгүй байсан. Тэр асуудлаа бол шийдсэн, шийдэж орж ирж байгаа юм.

2 дугаарт нь юу вэ гэхлээр тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулж орж ирсэн. Тогтвортой хөгжлийн нийт 17 зорилт байгаад байдаг. Тэгэхлээр Монгол Улсад хамааралтай нь 16 шалгуур үзүүлэлт байгаа. Тэр бүгдийг бид 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдуулаад орж ирж байгаа юм. Энэ маань өөрөөр хэлбэл бидний Монгол Улсын гадаад улсад хүлээж байгаа үүргээ бол бид энэ 5 жилийн үндсэн чиглэлээр биелүүлж орж ирж байна.

Ц.Сандаг-Очир: Цэдэвсүрэн дарга, ажлын хэсгийн 8 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: Сандаг-Очир даргын асуултад хариулъя. Төрийн албаны бүтээмжийн асуудлыг ер нь Дэлхийн банкны засаглалын яг өөрийнх нь үзүүлэлтээр Засгийн газрын үр нөлөөний тайлангаар нь дандаа үзүүлэлтүүд гардаг. Энэний дагуу Засгийн газар, Эдийн засгийн хөгжлийн яам ахлаад, Засгийн газар энэ тайланг гаргах дээр нь анхаарч ажиллана гэж байгаа.

Би 2 юман дээр нь илүү тайлбараа өгье. Төрийн албанд энэ чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ, ялангуяа сул орон тооны нөхөн бүрдүүлэлтийг хийнэ гээд. Түрүүн Идэрбат гишүүний юун дээр товчхон нөгөө хариулаад, минут дуусчихсан. 2024, 2025 оны байдлаар энэ хуульд заасны дагуу сул орон тооны тусгай шалгалтуудыг Төрийн албаны зөвлөл болон яам, агентлаг, Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлдэг. Бид энэ сул орон тоог хэрэгжүүлэхдээ нийт өрсөлдөж байгаа болон тэнцсэн хүмүүсийн тооны харьцааг гаргадаг л даа. Тэгэхээр энийг яаж гардаг юм бэ гэхээр нийт захиалга өгсөн хүмүүсээ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя, 8 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: Захиалга өгсөн орон тооноос нөхөгдсөн орон тоо маань одоогийн байдлаар энэ 47 хувь гэдэг нь энэ дээр суурь хувь маань болж байгаа юм. Тэгээд яагаад 47 хувийг бид 70 руу оруулъя гэхээр сул орон тоо төдийлөн сайн нөхөгдөж чадахгүй байна. Сонгон шалгаруулалтад орж байгаа хүмүүсийн асуудал ч байна, тавигдаж байгаа шаардлагыг өндөрсгөсөнтэй холбоотой асуудлууд ч байна. Гол нь шалгалт өгч байгаа хүмүүсийн тэнцэлтийн байдал төдийлөн хангалттай биш байгаа. Энийг нэлээн нэмэгдүүлье гэж төлөвлөж орж ирж байгаа.

Дээрээс нь хууль бус томилгооны асуудлууд. Хууль бус томилгоог 2024 2025 онд Төрийн албаны зөвлөлөөс нийлбэр дүнгээрээ 15 мянга гаруй албан тушаал дээр хийж үзлээ. Энэ нь нийт манай төрийн албан хаагчдын 40, ТЗ-ийнхнийг авч үзэхэд 40 гаруй хувь дээр нь бид энэ шалгалтыг хийсэн. Энэ шалгалтыг хийгээд,

энийгээ үзэхээр 630 гаруй зөрчил илэрснээс өнөөдрийн байдлаар 83 хувийн гүйцэтгэл сайтай явж байна.

Ц.Сандаг-Очир: Ахиад гүйцээгээд хариулчихъя, 8 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: 20 хувийн гүйцэтгэл дээр бид хойноос нь хөөцөлдөж байна, энэ хууль бус томилгоонуудыг арилгах асуудлыг. Тэгэхээр энэ маань нийт төрийн албан хаагчдын маань томилгооны 3 хувьтай тэнцэж байгаа учраас хууль бус томилгоог бид ямар ч байсан энэ 5 жилийн хугацаанд 2 хувь хүртэл буулгана гэдэг нь ер хуулийн хэрэгжилтийг илүү сайн хангуулна гэдэг тал дээрээ ажиллана л гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: 6 номерын микрофон, шударга байдлын үнэлгээг.

Х.Сүрэнхорол: Төрийн бүтээмжтэй холбоотой хариултыг нь өгчихье. 5 жилийн үндсэн чиглэл дээр төрийн бүтээмжийг дээшлүүлэхтэй холбоотой хэд хэдэн үр дүнгүүдийг тусгасан байгаад байгаа. Үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 7.3.2 дээр төрийн байгууллагын бүтэц, орон тоо, чиг үүрэг, орон тоог оновчтой тогтоох замаар чадахуйн зарчимд суурилсан, оновчтой чиг үүрэг, бүтэц бүхий цомхон, чадварлаг төрийн албыг бэхжүүлнэ гэсэн үр дүнг тусгасан байгаад байгаа. 7.3.1-д болохлоор ур чадварт суурилсан томилгоог төлөвшүүлэх замаар төрийн албанд чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ гээд тусгасан байгаа. Тэгээд холбогдох үр дүндээ харьцах өөрөөр хэлбэл шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнээ яаж тусгасан бэ гэхлээр 7.3.1.1 дээр төрийн албаны сул орон тооны нөхөн бүрдүүлэлт 47 хувьтай байгаад байгаа. Одоо бол 2024 оны суурь дүн, статистик дүн нь. Тэгээд 2030 онд 70 хувьд хүргэхээр туссан байгаад байгаа. 7.3.2 дээр удирдах, гүйцэтгэх албан хаагчийн харьцаа 9,2 хувь байгаа 2024 оны дүнгээр. Энийг бол.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Хөрөнгө оруулалтыг хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Мөнх-Эрдэнэ: Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь 5 жилийн үндсэн чиглэлийнхээ ажлуудыг гүйцээхэд шаардлагатай дэд бүтцийн болон хөгжлийн төслүүдийг тусгаж байгаа. Бодлогын хувьд 4.1 дүгээр хавсралт бол санхүүжилт нь аль хэдийн шийдэгдсэн төслүүд, 4.2 дугаар хавсралт бол өмнөх санхүүжилт нь шийдэгдсэн төслүүдээ яг тавиад, тэрнийхээ шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан онцлогтой. 4.3 бол ач холбогдлын хувьд өндөр ач холбогдолтой, санхүүжилтийг нь хайж олоод, шийдвэрлээд хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзсэн төслүүд. 4.4 бол ТЭЗҮ-г нь боловсруулах хэрэгтэй гэж үзсэн төслүүд. Өөрөөр хэлбэл үе шатыг нь нарийвчлан заасан байгаа.

Нөгөө талдаа санхүүжилтийг нь хайж олохдоо заавал улсын төсвөөр биш, төр, хувийн хэвшлийн түншлэл болон мөн 100 хувь хувийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр шийдвэрлэх боломжтой гэж үзсэн төслүүдийг тусгаж байгаа.

Ц.Сандаг-Очир: Тэгээд наадах чинь эх үүсвэр нь олдохгүй бол яах юм бэ? 5 жилийн дараа биелэлтийг чинь доош нь татна шүү дээ. Энэ 70, 80 төсөл, хөтөлбөрүүд байна шүү дээ эх үүсвэргүй байгаа. Тэгээд энэ чинь биелэлтээс чинь доош нь татах уу? 5 жилийн дараа эх үүсвэр олдсонгүй гээд, та нар одоо хайх юм ярьж байна шүү дээ. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Мөнх-Эрдэнэ: Тийм, улсын хөгжлийн бодлогын хүрээнд тусгагдаж байгаа төслүүд учраас хариуцсан салбар яамнууд, хариуцсан нэгжүүд өөрсдөө эх үүсвэрийг нь хайж олоод, хувийн хэвшлийн түншлэгч нараа эсвэл хайж олоод энэ төслийг хэрэгжүүлэх ёстой л гэсэн үүрэг хүлээнэ. Тэгээд олж, хайж олж чадахгүй, хэрэгжүүлж чадахгүй бол хэрэгжилт нь хэрэгжээгүй л гэж дүгнэгдэнэ.

Ц.Сандаг-Очир: Их Хурлын гишүүн Хэрлэн гишүүн асуултаа асууя. Хэрлэн гишүүнийг нэмчих.

Б.Хэрлэн: Тэгэхээр Төрийн албаны зөвлөлд хандаж 2 асуух зүйл байна. Нэгдүгээрх нь цахим засаглал. Монгол бол цахим засаглалаараа нэлээн дэлхийн хэмжээнд дээгүүр явж байгаа улс орны нэгд тооцогддог. Төрийн олон үйлчилгээ цахимжиж байгаа. Энэ нь өнөөдөр төрийн албан хаагчдын тоонд, төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварт тавигдах шаардлагад тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа. Магадгүй энэ бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, тоог илүү багасгах ийм нөхцөлийг бүрдүүлж байгаа. Энэ тал дээр ирэх хөгжлийн 5 чиглэлд Төрийн албаны зөвлөлөөс яг ямар бодлого баримталж байгаа юм бэ, танайд энэ талаар судалгаа ер нь байгаа юу 1 дүгээрт?

2 дугаарт сая төрийн албан хаагчдын нөгөө мэргэшсэн ийм төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулна гээд ярьж байна. Тэгээд энэ дээрээ орон тоо нөхөгдөхгүй байгаа байдлын тухай сая тайлбарлаж байна л даа. Тэгэхээр ер нь энэ нэг талаасаа төрийн албан хаагчдын албанд орохоор өгч байгаа шалгалт өгч байгаа хүмүүсийн чадвар хүрэхгүй байна гэж байна. Нөгөө талаасаа ердөөсөө сул болсон орон тоо нөхөгдөхгүй байна, энэ 47 хувьтай яваад байна гэж байна. Тэгэхээр энэ орон тоо нөхөгдөхгүй байгаад байгаагийн учир шалтгааныг ер нь яг юу гэж харж байгаа юм бэ? Магадгүй энэ чинь хуультай чинь холбоотой байгаа юм биш биз? Өөрөөр хэлбэл төрийн албанд тодорхой албан тушаалд тавьж байгаа тусгай шаардлагууд чинь дэндүү нэг явцуу тийм шаардлагууд тавьчихсан учраас магадгүй ажилласан жилийн шаардлага нь ч өндөр байдаг юм уу, эсвэл мэргэжлийн мэргэшсэн байдлын шаардлага чинь яг тухайн албан тушаалд тэр болгон тохирохгүй байгаад байгаагаас болоод сул орон тоонууд чинь нөхөгдөхгүй, ингээд зарим байгууллагууд төрийн байгууллагуудад бүрэн бүтэн орон тоогоороо ажиллаж чадахгүй, хүмүүс хэн нэгний ажлыг хавсарч хийгээд, ажлын ачаалал нь нэмэгдээд байдаг тал байдаг юм биш биз дээ? Тэгэхээр энэ орон тоо бүрэн нөхөгдөхгүй байгаад байгааг та нар арай өөр талаас нь харж үзэх ёстой юм биш үү? Хуулийн зохицуулалттайгаа холбож харах ёстой юм биш үү гэж би 2 дугаарт нь энийг асууж хэлмээр байна?

3 дахь нь ер нь ингээд энэ бүрэн орон тоогоороо ажиллаагүй байгаа тохиолдолд, энэ ер нь бүрэн орон тоогоороо ажиллах энэ үүрэг хариуцлагыг төрийн байгууллага дээр хэн хүлээх юм бэ? Хэрвээ удирдах албан тушаалтан төрийн албан хаагчийг өөрт ноогдсон ажил үүргээ яг ажлын байрныхаа тодорхойлолтод заасан ажил үүргээ хийгээд, гүйцэтгэх тэр боломж үүргийг, тэр боломжийг удирдах албан тушаалтан бүрдүүлж байх ёстой. Гэтэл сул орон тоонууд тэнд цаана нь байгаад байдаг, тэр ажлыг нь хэн нэгэн хавсарч хийгээд байдаг, ажлын ачаалал нь нэмэгдээд байдаг, авч байгаа цалин мөнгө нь нэг их нэмэгдэхгүй байгаад байдаг. Тэгэхээр энэ ингэж орон тоогоо бүрэн ажиллуулахгүй байгаа удирдах албан тушаалтанд ер нь та хариуцлага хүлээлгэдэг үү, энд энэ хуулийн зохицуулалт байна уу, та нар энэ дээр ер нь яаж ажилладаг юм бэ гэж? Би ийм 3 юмыг тодруулж асууя. Энийг цаашдаа энэ 5 жилд, ирэх 5 жилд ер нь яаж засах гээд байгаа юм бэ?

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүний асуултад ажлын хэсгийн 6 номерын микрофон. Ажлын хэсгийн 8 номерын микрофон, Цэдэвсүрэн дарга.

Л.Цэдэвсүрэн: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Цахимжилттай холбоотой асуудал төрийн албанд цахимжилтыг нэвтрүүлснээр орон тооны хөдөлгөөн зохицуулалт яах вэ гээд. Манай байгууллагаас барьж байгаа чиглэл болон ер нь манай байгууллага бол төрийн байгууллагуудад зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хуулийн хэрэгжилтийг хянах, алдсан алдаа зөрчлийг илрүүлэх, түүнийг засан сайжруулах иймэрхүү чиглэл, чиг үүргийг хэрэгжүүлдэг. Бид Засгийн газар болон Улсын Их Хурлын холбогдох байгууллагууд, төрийн байгууллагууддаа өгч байгаа зөвлөгөө чиглэлүүд юу вэ гэхээр цахимжилтын асуудлыг мэдээллийн системийн интеграцыг зөв хиймээр байна. Төрийн байгууллага болгон дээр маш олон төрлийн цахим системүүд ингээд харилцан уялдаагүй ажиллаад байгаа нь нэг талаасаа энэ төрийн албан хаагчдын тоог бууруулахад төдийлөн нөлөөлөл үзүүлэхгүй байгаа юм биш үү гэдэг зүйлийг ярьж, Цахим хөгжил, инновацын яамтай энэ дээр нэлээн олон арга хэмжээнүүдийг хийж эхэлж байна.

Нөгөө талаасаа цахимжилттай холбоотой, төрийн албаны цахимжилттай холбоотой зүйл дээр энэ сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон томилгоотой холбоотой бүх үйл ажиллагаануудыг бид энэ оноос эхлээд бүрэн цахим хэлбэр лүү оруулж байна.

3 дахь дээр нь манай байгууллага цахимжилтыг энэ хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж чадаж байна. Тэгэхээр төрийн албанд цахимжилт нэвтэрснээрээ албан тушаалын орон тоо хэт их бууралттай байна гэдэг бол бас нэг их тийм зөв шийдэл биш. Яг ямар тохиолдолд албан тушаалуудыг бий болгох вэ, ямар тохиолдолд албан тушаалуудыг нийлүүлж, нэгтгэж энэ үйл ажиллагаа нь цахимжих вэ гэдгийг Цахим хөгжил, инновацын яамтай хамтраад хийж байгаа. Энэ Цахим яамны Төрийн нарийн бичгийн дарга ирчихсэн сууж байна. Энэ дээр нэмэлт тайлбар өгөх байх.

Сул орон тоо нөхөгдөхгүй байгаа асуудал хуультай холбоотой гэж төдийлөн хэлэх боломж бас муу. Яагаад гэхээр хуульд албан тушаал гэдгээсээ илүүтэй ангилал, зэрэглэлд тавигдаж байгаа шаардлагуудыг нэлээн сайн зааж өгдөг. Бид яагаад сул орон тоог нөхөхөд ийм удаашралтай байгаа юм бэ гэхээр томилох эрх бүхий этгээд буюу байгууллагын удирдлагуудын энэ албан тушаалын нэршлийг зөв бий болгох, захиалгуудыг өгөх, сонгон шалгаруулалтыг хуульд заасан цаг хугацаанд нь явуулах, ялангуяа албан хаагчдыг меритийн зарчмаар бэлтгэх тал дээр үнэндээ дутагдалтай байна. Энийг хийлгэхийн тулд бүх яам, агентлагууд дээр чадахуйн зарчмын аудитыг хийгээд эхэлчихлээ. Тэгэхээр энэ дээр бид сургалт хийх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай бол бүх яам, агентлагийн энэ томилох эрх бүхий этгээдүүд дээр 11 сараас эхлээд сургалтыг Удирдлагын академитай хамтраад хийгээд явж байна л даа. Тэгэхээр энэ нөгөө хүн нь муу гэдгээсээ илүүтэй, томилох эрх бүхий этгээдийн өөрийнх нь ажлын менежментийн асуудал бол энэ дээр нэлээн их нөлөө үзүүлээд байгаа гэдгийг хэлэх нь зөв гэж бодож байгаа. Бүрэн орон тоогоороо ажиллах, ажиллуулахыг бол тэр байгууллагын удирдах ажилтан өөрөө хариуцах ёстой. Энэ дээр яг бүрэн биш байх.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд 1 минут. 8 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: Батлагдсан орон тооныхоо хүрээнд яг хүмүүсээ бүрэн авч ажиллуулахгүй байгаа бол тэр хүнд хариуцлага тооцох нь тэр хүнийг томилсон байгууллагын эрхийн асуудал байгаа. Бид энэ дээр ямар зөвлөгөө, дэмжлэг үзүүлж байна гэхээр та нар сул орон тоо гарангуут аль болохоор чадахуйн зарчмын хүрээнд дотроосоо сонгон шалгаруулалтууд хийгээд томил. Хэрвээ тэгж чадахгүй байгаа бол ижил төстэй төрийн байгууллагуудаас сэлгэн шилжих хэлбэрээр томилгоонуудыг хий, бүүр боломжгүй байгаа бол нээлттэй сонгон шалгаруулалт явуул гэдэг энэ зөвлөгөө, зөвлөмжүүдийг бүх төрийн байгууллагуудад өгч, энэний дагуу сонгон шалгаруулалт болон томилгооны асуудлууд дээр нь дэмжлэг үзүүлээд ажиллаж байгаа.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя гишүүдээ. Нэгхэн зарчмын зөрүүтэй санал байна. Гишүүд санал хураалтад бэлдье. Ер нь гишүүд 2 хоногийн өмнө зарчмын зөрүүтэй саналаа Байнгын хороонд ирүүлсэн байх ёстой. Ингээд ирүүлсэн 1 зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 8.2 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “БҮСИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “8.2” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “Ажлын хэсэг-5.2, 8.2” гэж “Салбар” баганад “Бүх салбар” гэж, “Үр дүн” баганад “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Хууль, эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Засгийн газрын хэрэг эрхлэх газар” гэж, 3 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “БҮСИЙН ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “8.2” гэж, “Салбар” баганад “Бүх салбар” гэж, “Үр дүн” баганад “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хот, тосгоны эрх зүйн байдлыг зохицуулсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: -” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026 онд 100, 27 онд 100, 28 онд 100, 29 онд 100, 30 онд 100” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Хагас жил тутам, Хариуцах байгууллага: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир. Ийм зарчмын зөрүүтэй санал байна. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ. Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа. Монгол Улсыг 2026-аас 30 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Манайхаас Эдийн засгийн байнгын хороонд Бат-Эрдэнэ дарга байдаг юм байна. Санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ дарга танилцуулна.

14.39 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА